

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны дүгээр сарын....-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар

ТӨРӨӨС ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ, НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХ, ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХАНГАХАД БАРИМТЛАХ БОДЛОГО БАТЛАХ ТУХАЙ

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1-д заасан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 8.4, 8.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Төрөөс гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад баримтлах бодлого”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Төрөөс гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад баримтлах бодлого улсын хэмжээд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц. Нямдоржид, эрхэлсэн салбар, харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нат тус тус даалгасугай.

3. Төрөөс гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад баримтлах бодлогын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд, шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт жил бүр тусгаж гадаад улс, олон улсын байгууллагын зээл, хандив тусламжид хамруулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч. Хүрэлбаатар, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц. Нямдорж, аймаг нийслэлийн засаг дарга нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

У. ХҮРЭЛСҮХ

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

Ц. НЯМДОРЖ

ТӨРӨӨС ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ, НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХ, ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХАНГАХАД БАРИМТЛАХ БОДЛОГО

Нэг. Ерөнхий мэдээлэл

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын 2.4 дэх хэсэгт тогтвортой хөгжлийн засаглалын зорилт болон хүрэх түвшний шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, тогтоолын 2 дахь хэсэгт “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын дүнд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт тусган үе шаттайгаар хэрэгжүүлэх,” гэж заасан.

Түүнчлэн Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.3 дахь хэсэгт “Хүний эрх, эрх чөлөөг хангаж, Үндсэн хуульт байгууллагыг бататгаж, хууль дээдлэх ёс, Монгол төрийн залгамж чанар, үндэсний эв нэгдлийг сахин дээдэлж, төрийн удирдлагыг бэхжүүлэх, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, чөлөөт хэвлэл мэдээллийн төлөвшлийг дэмжиж, нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах нь дотоод аюулгүй байдлын үндэс мөн” гэж тодорхойлсон.

Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын дагуу аюулгүй байдлыг хангаж, гадаад харилцаа, олон улсын хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлэх нь Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын амжилттай хэрэгжүүлэх нэг үндсэн нөхцөл нь билээ.

Монгол Улсын Үндсэн хуульд заасан нийгмийн дэг журам хангах талаар хүлээлгэсэн чиг үүргийг хэрэгжүүлэхдээ төрт ёсны болон үндэсний уламжлал, зан заншлыг сэргээн хөгжүүлэх, эдийн засаг, нийгэм, улс төрийн бүхий л хүрээнд хууль тогтоомжийг сахиулах, түүний дотор гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэхэд чиглэсэн эдийн засаг, нийгэм, хууль зүйн цогцолбор арга хэмжээ авч хэрэгжүүлэх явдал зайлшгүй шаардлагатай болж байгааг харгалзан 1992 онд Монгол Улсын Их Хурлаас “Монгол улсад нийгмийн дэг журам хангах талаар төрөөс явуулах үл ажиллагааны үндсэн чиглэл”-ийг баталж байсан.

Монгол улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үе шат, баримтлах зарчим, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх зорилготой Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль 2015 онд батлагдан мөрдөгдөж байна.

2017 онд батлагдсан Цагдаагийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалтад цагдаагийн төв байгууллага нь агентлагийн нийтлэг чиг үүргийн хүрээнд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлын хангах чиглэлээр төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн талаар санал боловсруулах үүрэг гүйцэтгэхээр тусгагдсан.

Хууль зүйн салбар шинэчлэлийн хүрээнд Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль зэрэг олон хуулиуд шинэчлэн батлагдсан нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад удирдлага зохион байгуулалт, хүний нөөцийг чадавхжуулах, олон улсын жишигт хууль сахиулах ажиллагаанд нэвтэрч байгаа шинэ дэвшилтэт технологийг дагасан шинэ эрэлт, хэрэгцээ бий болж байна.

Ийнхүү иргэдийн аюулгүй орчинд амьдрах баталгааг бүрдүүлж хүний эрх, эрх чөлөөг хангахад нийгмийн эргэлт хэрэгцээг одоогийн гэмт хэрэгтэй тэмцэх,

нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад бүтэц, зохион байгуулалт, зохицуулалт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, хүний нөөцийн чадавх хангаж чадахгүй байгаа тул төрөөс баримтлах бодлогыг шинээр төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хоёр. Бодлогын зорилго, зарчим, зорилт

2.1. Бодлогын зорилго

Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны хууль тогтоомжийн хэрэгжилтэд, хяналт шинжилгээ хийх замаар эрх зүйн орчны уялдаа холбоог хангах нотолгоонд суурилсан технологийг нэвтрүүлэх, үйл ажиллагаа, санхүүжилтийн зохистой тогтолцоог бүрдүүлэн хүний эрх, эрх чөлөөг хангах хамгаалах, хангахад оршино.

2.2. Бодлогыг хэрэгжүүлэх зарчим

Бодлогыг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.

- 2.2.1. хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх;
- 2.2.2. төрийн болон албаны, байгууллага, хувь хүний нууцыг хангах;
- 2.2.3. нотолгоонд суурилсан, орчин үеийн хууль сахиулах техник, технологийн дэвшлийг нэвтрүүлсэн байна.
- 2.2.4. төрийн бодлогыг залгамж чанарыг хадгалсан байх;
- 2.2.5. төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, орон нутгийн иргэд, олон нийтийн оролцоог хангасан байх.

2.3. Бодлогыг хэрэгжүүлэх чиглэл, зорилт

Бодлогыг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ:

- 2.3.1. Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх;
- 2.3.2. нийтийн хэв журам хамгаалах;
- 2.3.3. Олон нийтийн аюулгүй байдлыг хангах

2.4. Бодлогын зорилтууд

Бодлогын зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд дараах зорилтыг дэвшүүлж байна.

2.4.1. Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээ тогтоосон актын хэрэгжилтийг хангах, тэдгээрийн боловсронгуй болгох чиглэлээр

2.4.1.1. Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль зэрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх замаар уялдаа холбоог ханган хийдэл, давхардал, зөрчилдөөнийг засах замаар эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

2.4.1.2. Монгол улсын олон улсын гэрээнд тусгагдсан гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах талаарх эрх зүйн орчныг боловсронгуй үүргийн хэрэгжилтийг хангах;

2.4.1.3. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах талаарх олон улсын гэрээ конвенцэд нэгдэн орох талаар судлах, батлах, хэрэгжилтийг хангах;

2.4.1.4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль болон тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийг төрийн Эрүүгийн бодлогын үзэл баримтлалд нийцүүлэн шинэчлэх;

2.4.1.5. Төрийн эрүүгийн бодлогын үзэл баримтлалд нийцүүлэн эрх бүхий албан тушаалтнаас дангаар болон хамтран баталж мөрдөж буй тушаал, заавар, журмуудыг шинэчлэх, уялдаа холбоог хангах;

2.4.1.6. Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад зохих үр нөлөө үзүүлэх нийгмийн тодорхой төрлийн харилцааг зохицуулах шаардлагатай хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээ тогтоосон болон захиргааны актууд батлагдах хууль, эрх зүйн орчин бий болгох хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх;

2.4.1.7. Гэмт хэрэг, зөрчлийн улмаас иргэн, хуулийн этгээдэд учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан сэргийлэх зорилгоор даатгалын системийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хохирогчид учирсан эдийн бус хохирлыг тооцох, арилгах арга аргачлал, эдийн засгийн зохицуулалтыг оновчтой болгох;

2.4.1.8. Гэмт хэрэг зөрчлийн талаарх эрх зүйн харилцан туслалцаа харилцан үзүүлэх, тогтоол биелүүлэх зорилгоор хүнийг шилжүүлэн авах, шилжүүлэн өгөх, ялтан шилжүүлэх зэрэг гэрээнүүдийг шинэчлэх, шинээр байгуулах ажлыг зохион байгуулах;

2.4.1.9. Олон улсын жишигт нийцсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах стандарт бий болгох, үр дүнд суурилсан хяналт шинжилгээ хийх мөрдүүлэх;

2.4.2. Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээний талаар

2.4.2.1. Хууль сахиулах үйл ажиллагааг бусад салбарын бодлогод тусган уялдуулж, нэгдсэн зохицуулалттайгаар хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлснээр хүн амын аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг сайжруулах;

2.4.2.2. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр үндэсний болон орон нутгийн түвшинд тогтвортой бүтэц бий болгон чадавхжуулах;

2.4.2.3. Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын улс төрөөс хараат бус ажиллах төрийн албаны чадахуйн (Мерит) тогтолцоог төлөвшүүлэх, нөхцөл бололцоог хангах

2.4.2.4. Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах байгууллагуудын бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааг тухайн нутаг дэвсгэрийн эрүү, хэв журмын нөхцөл байдал, онцлогт уялдуулан судалгаанд тулгуурлан зохион байгуулах;

2.4.2.5. Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах байгууллагын алба хаагч, ажилтны ажлын ачааллыг шинэчлэх ухааны үндэслэлтэйгээр тодорхойлж, олон улсын жишигт нийцүүлэх талаар зохист арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;

2.4.2.6. Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах байгууллагын алба хаагч, ажилтнуудын үр дүнгийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтыг Төрийн албаны хууль тогтоомжийн дагуу шинэчлэн боловсруулж, ажил дүгнэх үзүүлэлт, мэргэжлийн мэдлэг, ур чадварыг үнэлэх аргачлалыг боловсруулах;

2.4.2.7. Шүүх эрх мэдлийн болон мөрдөн шалгах, хууль сахиулах байгууллагуудын жил бүрийн төсвийн төсөлд эрүүгийн болон зөрчлийг шалган

шийдвэрлэх ажиллагааны зардлыг хууль тогтоомж, холбогдох журамд заасны дагуу тусган батлах, зарцуулах, тайлагнах:

2.4.2.8. Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах салбарын бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламжийг тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд зарцуулах;

2.4.2.9. Алба хаагч, албан тушаалтны ажиллах нөхцөлийг ханган нийгэм, эдийн засгийн баталгааг сайжруулах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бололцоог хангах;

2.4.2.10. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах хүрээнд гэнэтийн аюул, байгалийн гамшиг, нийтийг хамарсан халдварт өвчний дэгдэлт зэрэг онцгой байдлын үеийн нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ шуурхай авах чадавхыг бүрдүүлэх:

2.4.2.11. Олон улсад бүртгэгдэж буй шинэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийг холбогдох хүчин зүйлтэй нь уялдуулан судлах, түүнээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээг хэрэгжүүлэх;

2.4.2.12. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, цаашдын чиг хандлагыг тодорхойлох чадавхыг бэхжүүлэх;

2.4.3. Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын алба хаагчдыг чадвахижуулах талаар

2.4.3.1. Эрдэм шинжилгээ, сургалтын байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилгоор эдийн засаг, зохион байгуулалтын цогцолбор арга хэмжээ авч хэрэгжүүлэн шүүх эрх мэдлийн болон мөрдөн шалгах, хууль сахиулах ажиллагааг хэрэгжүүлэгчдийн төгсөлтийн өмнөх сургалтыг бэлтгэж ирсэн тогтолцоог олон улсын жишиг хандлагад нийцүүлэн сургалтын агуулгын стандарт, хөтөлбөрийг шинэчлэн багшлах бүрэлдэхүүнийг чадвахжуулах

2.4.3.2. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад олон улсын жишиг туршлага, технологийн дэвшил, инновацийг нэвтрүүлэх зорилгоор алба хаагч, албан тушаалтныг өндөр хөгжилтэй оронд бэлтгэх, гадаад улсад бэлтгэгдсэн алба хаагч, албан тушаалтныг өөрийн мэдлэг, туршлагаа түгээн дэлгэрүүлэхийг дэмжих:

2.4.3.3. Төгсөлтийн дараах сургалтын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн шүүх эрх мэдлийн болон мөрдөн шалгах, хууль сахиулах байгууллагын албаны сургалтын агуулга, стандарт, хөтөлбөрийг карьерын тогтолцоонд тургуулан мэргэшүүлэх, шаталсан давтан сургалтыг шинэчлэхийн зэрэгцээ сургалтын түшиц нэгжийг байгуулах, сургалтын үйл ажиллагаанд түшиц байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбоо, суралцагчийн оролцоог нэмэгдүүлэх:

2.4.3.4. Сургалтын орчныг сайжруулан сургагч алба хаагчдын чадавхыг дээшлүүлэн удирдах албан тушаалтан, албан хаагч, албан тушаалтнуудыг тодорхой төрлийн сургалтад хамруулж хамруулах, ур чадвар, чадамжийг дээшлүүлэх:

2.4.3.5. Их дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба хаагч, албан тушаалтны мэдлэг боловсрол, мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;

2.4.3.6. Гадаадын их, дээд сургууль, хүрээлэн, хууль сахиулах байгууллагатай хамтын ажиллагааны хүрээнд судлаач, алба хаагч, албан тушаалтан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх;

2.4.3.7. Олон улсын гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах олон нийтийн аюулгүй байдлыг хангах тэргүүн туршлагыг нэвтрүүлэх холбогдох нэг сэдэвт бүтээл, ном, гарын авлагын хүртээмжийг нэмэгдүүлэх;

2.4.3.8. Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хүний нөөцийг төлөвлөх, сургах, урамшуулах арга хэмжээг хэрэгжүүлэх;

2.4.3.9. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр нэн шаардлагатай мэргэшлээр алба хаагч, ажилтан бэлтгэх, орон нутгийг алба хаагчдаар хангах чиглэлээр хүний нөөцийг төлөвлөх, сургах, урамшуулах арга хэмжээг хэрэгжүүлэх;

2.4.3.10. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэгчдийн цалингийн шатлал, албан тушаалын ангилал, зэрэглэлийг ажлын ачаалал, гүйцэтгэл, хариуцлага, ажлын төрөл, онцлогтой уялдуулан тогтоох, шинэчлэх;

2.4.3.11. Алба хаагч, ажилтны нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр хөтөлбөр боловсруулж хамт олон, нутгийн захиргааны байгууллагын оролцоо, хамтын ажиллагаа болон салбарын хөдөлмөр, нийгмийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэх;

2.4.4. Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад орчин үеийн мөрдөн шалгах, хууль сахиулах техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх чиглэлээр

2.4.4.1. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах салбарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын санхүүжилтийг нэмэгдүүлэх, салбарын инноваци, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тэргүүлэх чиглэлээр тодорхойлж, судалгааны ажлын үр дүнг практикт өргөнөөр нэвтрүүлэх;

2.4.4.2. Монгол улсын дотоод аюулгүй байдлын эрэлт хэрэгцээ, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах технологийн шаардлагад үндэслэн нэгдсэн төлөвлөлтийг бий болгох;

2.4.4.3. Монгол улсад шинээр бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зарим үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэвшилтэт технологийг нэвтрүүлэх асуудлыг санхүүжилтийн болон татварын бодлогоор дэмжих;

2.4.4.4. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд ашиглагдах хэрэгсэл, тоног, төхөөрөмж худалдан авах ажиллагааны үр ашгийг сайжруулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх;

2.4.4.5. Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад мэдээллийн нэгдсэн тогтолцоог нэвтрүүлж, төрийн байгууллагуудын мэдээллийн сангийн бүрдүүлэлт, түүний ашиглалтыг сайжруулах, харилцан мэдээлэл шуурхай солилцох тогтолцоог бүрдүүлэх;

2.4.4.6. Үндэсний аюулгүй байдлыг хангах, хууль сахиулах үйл ажиллагааны чиглэлээр шинжлэх ухааны үндэслэлтэй суурь болон хавсарга судалгаа хийж, судалгааны ажлын үр дүн, инновацийг практикт нэвтрүүлэх замаар эрдэм шинжилгээ, судалгааны ажлын цар хүрээг өргөжүүлэх;

2.4.4.7. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд шаардлагатай техник, технологийг үйлдвэрлэх, засварлах, туршилт явуулах зориулалтай техник, технологийн паркийг Хууль сахиулах их сургуулийн дэргэд байгуулж, инновацийн үндэсний тогтолцоонд нийцүүлэх;

2.4.4.8. Хүний аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор камержуулалтыг улсын стандарт боловсруулж, шаардлагад нийцсэн “ССТV” камерын нэгдсэн хяналтын системийг хот суурин газар, улсын чанартай зам, тээврийн хэрэгсэлд нэвтрүүлэх, ашиглах нэгдсэн тогтолцоог бий болгох ажлыг төв, орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

2.4.4.9. Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор олон улсын хууль сахиулах туршлагыг байнга эрэлхийлэх, судалгаа, шинжилгээ хийх, практикт нэвтрүүлэх талаар бололцоотой бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2.4.4.10. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад орчин үеийн арга, техник, технологи /полиграф, профайлинг, нүүр царай, дуу хоолой, дүрс бичлэг, фото зургаар таних, явуулын шинжилгээний лаборатори, генетикийн сан, шинэ төрлийн шинжилгээ гэх мэт/ нэвтрүүлэх ажлыг Засгийн газрын тусгай сангаас санхүүжүүлэх ажлыг зохион байгуулах;

2.4.4.11. Шүүх эрх мэдлийн болон мөрдөн шалгах, хууль сахиулах байгууллагуудын аюулгүй байдлыг хангах, техник хангамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх;

2.4.5. Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад төр байгууллага, иргэдийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр

2.4.5.1. Эрүү болон хэв журмын нөхцөл байдлын судалгаанд үндэслэн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, үр дагаврыг тандах, хүн амын аюулгүй орчинд ажиллаж амьдрахад нөлөөлж байгаа сөрөг хүчин зүйлийг бууруулах, арилгах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх;

2.4.5.2. Хүн амд, ялангуяа цэцэрлэг, ерөнхий боловсролын болон их дээд, сургууль, коллежид суралцагчдад гэмт хэрэг зөрчлөөс урьдчилсан сэргийлэх мэдлэг олгох, ухуулга нөлөөлөл, мэдээлэл сурталчилгаа хийх, иргэдийн гэмт хэрэгтэнтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах талаарх хүчин чармайлтыг дэмжих, урамшуулах, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх, иргэдийн аюулгүй байдлыг хангах зан үйл, аж төрөх хэв маягийг төлөвшүүлэх

2.4.5.3. Шүүх эрх мэдлийн болон мөрдөн шалгах, хууль сахиулах байгууллагуудын үйлчилгээ ил тод байдлыг хангахад иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог нэмэгдүүлж, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх;

2.4.5.4. Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын үйл ажиллагаа, санаачилгыг дэмжих;

2.4.5.5. Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль зэрэг хуулиудыг нийтэд сурталчлан таниулах ажлын үр нөлөөг дээшлүүлэх;

2.4.5.6. Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад хэвлэл мэдээллийн байгууллагын хамт ажиллагааг бүхий л хэлбэрээр ашиглах боломжийг бүрдүүлэх;

2.4.5.7. Улс дамнасан болон зохион байгуулалттай гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, тэр дундаа хүүхэд эмэгтэйчүүдийг гэмт явдлын тандалт, судалгааг тогтмол хийж, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх;

2.4.5.8. Гэр бүлийн хүчирхийлэл болон Замын хөдөлгөөний аюулгүй байдлын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх аюулгүй байдлын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах ;

2.4.5.9. Иргэн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй оролцоонд тулгуурлан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нийтийн хэв журам, хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах хяналтын тогтолцоог бүрдүүлэх

2.4.5.10. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр төрийн байгууллагын зарим чиг үүргийг хэвийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж санхүүжилт олгох замаар үйл ажиллагааны тасралтгүй, тогтвортой байдлыг хангах.

Гурав. Бодлогыг хэрэгжүүлэх үе шат

3.1. Бодлогыг 2017-2026 онд дараах үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

- Нэгдүгээр үе шат: 2017-2021 он;
- Хоёрдугаар үе шат: 2022-2026 он.

Дөрөв. Бодлогын үр нөлөө, бүтээгдэхүүний шалгуур үзүүлэлт

4.1. Энэхүү бодлогыг хэрэгжүүлснээр “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал- 2030 ”-ын 2.4-т заасан Тогтвортой хөгжлийн засаглалын зорилт болон хүрэх түвшний шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан байна.

4.2. Бодлогын хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг 2017 оны тоон мэдээллийг суурь үзүүлэлт болгон олон улсын жишигт стандарт шалгуур үзүүлэлтийг харгалзан тогтооно.

Тав. Бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэр

5.1. Бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ нь хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний батлах үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр тодорхойлогдох бөгөөд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлнэ.

5.2. Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургаа дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэн аюулгүй орчинд амьдрах...”, Арванес дүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасны дагуу бодлогыг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөрийн санхүүжилтийг төрөөс тэргүүн ээлжинд анхаарна.

5.3. Бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг 5.2-т заасан төлөвлөгөө хөтөлбөрт тусган хэрэгжүүлнэ.

5.4. Бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

5.4.1. улсын болон орон нутгийн төсөв;

5.4.2. хандивлагч орон болон олон улсын байгууллагын хандив, зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

5.4.3. Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт;

5.4.5. бусад эх үүсвэр.

Зургаа. Бодлогын хэрэгжилтийн хяналт- шинжилгээ, үнэлгээ

6.1. Бодлогын хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ үнэлгээг хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хоёр жил тутамд, хөндлөнгийн үнэлгээг дөрвөн жил тутамд хийж дүнг Засгийн газарт танилцуулна.

6.2. Хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь бодлогын хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулж, шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөвт тусгана.

--- оОо ---